



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/799

Булган сум

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын Улсын байцаагч
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч
	Байгаль орчны газрын Агаарын бохирдол, хог хаягдал, химийн бодис хариуцсан мэргэжилтэн
	"Авто Тээврийн Үндэсний төв" ТӨҮГ-ын Булган дахь салбарын техникийн инженер
	"Булган мээж" ОНӨХХК-ийн ерөнхий инженер
	"Энержи плас" ХХК-ийн ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга:	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн ерөнхий инженер

2. Сумын агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлж, ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын дүнг аймгийн хэмжээнд нэгтгэж, агаарын бохирдлын ялгарлын хэмжээ тооцохыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд

6324011195

үүрэг болгосугай.

4. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрөөс дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулж, нэгдсэн дүнг тус оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/798 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР

